

**БУЛГАН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.12.20

Зорилго: Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Арга зүй: Монгол улсын Засгийн газрын 2020 оны 106 дүгээр тогтоол, ХХААХҮ-ийн сайдын А/159 дугаар тушаал "ХХААХҮ-ийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр, Аймгийн засаг дарга, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөр, Аймгийн жилийн төлөвлөгөө, ХХААХҮ-ийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, сумдын мал эмнэлэг үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, 2023 оны жилийн эцсийн тайлангуудад үндэслэн хийв.


Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2023 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

**I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**1.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ "ШИНЭ ХӨГЖЛИЙН ЗАМ" ХӨТӨЛБӨР
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн.

Төлөвлөгөөнд тус салбарын 25 зорилтын 48 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Арга хэмжээний хэрэгжилт 91.6 хувьтай байна.



Үр дүнтэй хэрэгжсэн арга хэмжээ:

Малчдыг мэдлэгжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалтанд Нийт 2160 хүн хамруулсан.

Чинээлэг малчин" хөтөлбөрийг "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөртэй уялдуулж МАА-н салбарт 140 зөгийн бүл, 608 толгой шилмэл сүрэг, цэвэр үүлдрийн 64 бух, хадлангийн иж бүрэн техник тоног төхөөрөмж тракторын хамт нийт 1,927.0 сая төгрөгийн санхүүжилтийг сумдад олгосон байна. Хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVIII дугаар хуралдаанд танилцуулж, 83.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн.

Бүрэгхангай сумын "Бодь алтай хийц" ХХК хоногт 15 тонны хүчин чадал бүхий багсармал тэжээлийн үйлдвэр байгуулж, 100 тн тэжээл үйлдвэрлэсэн. Энэ онд аймгийн хэмжээнд тэжээлийн ургамал 5609 га-д тариалж, өмнөх оноос 2285 га талбайгаар нэмэгдэж, 16.0 мянган тонн ургац хураан авсан.

Хутаг- Өндөр мах маркет" ХХК нь Иран улсад 370 тн мах экспортод нийлүүлж, БНХАУ-д мах экспортлох зөвшөөрөл авч, улсын нөөцөд 50 тн мах нийлүүлэхээр бэлтгэж байна. Энэ онд дотоодын хэрэгцээнд 474.0 мянган толгой мал хэрэглэж, 715.0 мянган толгой малыг зах зээлд нийлүүлж, нийт 1189.0 мянган малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан.

Хөдөөгийн хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 худаг, малчдын санаачилгаар 2 худаг нийт 18 инженерийн хийцтэй худаг гаргасан. Мөн Байгаль хамгаалах сангийн 65.0 сая төгрөгөөр 10 сумдад булаг шандын эхийг хашиж хамгаалсан.

2023 онд 26.7 мянга буюу 1.9 хувиар нэмэгдэж, 906.3 мянгад хүрч нийт сүрэгт эзлэх өндөр ашиг шимтэй малын тоо 24.4 хувьд хүрсэн байна

Хутаг-Өндөр сумын "Гурванборхууд" ХХК-ийн "Арвайн гурил", Хялганат тосгоны "Сүргийн нуга" ХХК-ийн "Зөгийн бал" зэрэг бүтээгдэхүүн Органикийн хуулийн хүрээнд баталгаажсан орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болж байна. "Гурванборхууд" ХХК нь "Хүнсний хувьсгал" хөдөлгөөний хүрээнд 2023 оны "Шилдэг 35 хүнсний үйлдвэр"-ийн нэгээр шалгарлаа.

Аймгийн хэмжээнд хоршоо хөгжүүлэх сан нь 3.9 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй. 2023 оны 11 сарын 30-ний байдлаар 374 зээлдэгч 4.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, муу зээлийн ангилалд 167 зээлдэгч байна. Өмнөх онтой харьцуулахад 28 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэгжилт удааширалтай –Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ /30-50 хувь/

- 2.3.4.5 Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж, хөгжүүлэх
- 5.1.2. 1. "Булган үйлдвэр технологийн төв"-д гадаад дотоодын хөрөнгө оруулалт татаж, эхний ээлжинд 1100 тн ноос угаах үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагчийг бодлогоор дэмжих
- 5.1.2.2. Аймгийн төв болон сумдад мал нядалгааны цэг байгуулж, хүнсний эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх

Эдгээр 3 арга хэмжээ нь хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр батлагдсанаас хойших хугацаанд хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын олон ажил, арга хэмжээг дэс дараалан авч хэрэгжүүлэн ажиллаа.

Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хөдөө аж ахуйн салбарт хамааралтай 28 зорилтын 54 заалт арга хэмжээг хяналтандаа авч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаа. Төлөвлөсөн арга хэмжээнээс үр дүнтэй Үр дүнтэй 100 хувь - 33 арга хэмжээ, 90 хувь -2 арга хэмжээ, 70 хувь - 9 арга хэмжээ, 50 хувь-4, 30 хувь-6, хугацаа болоогүй 5 арга хэмжээнд хяналт шинжилгээ хийж, гүйцэтгэлийг 92,0 хувиар үнэлсэн.

**1.2.САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИЖ БУЙ ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД
ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН**

	Бүгд	“Газар тариалангийн тогтвортой хөгжил”	“Чинээлэг иалчин”	“Бэлчээрийн менежмент”
Нийт зорилтын тоо	24	11	7	6
Хэрэгжилтийн хувь	90.6	93.4	90,06	88.0

Салбарын дэд хөтөлбөрийн хэрэгжилтүүдийг жилийн эцсийн байдлаар аймгийн ЗДЗХ,
аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн дүгнүүлсэн.

Ололттой тал:

- Тариалангийн талбайн эзэмшилт ашиглалт нэмэгдэж, тогтвортой тариалж байна.
- Цахим систем нэвтрүүлснээр гарал үүслийн гэрчилгээ, бордооны татаас, техникийн дэмжлэг, буудайн болон хүнсний ногооны урамшууллыг цахимаар олгож, тариаланчдын баримт бичиг бүрдүүлэх ажлыг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэсэн үр дүнтэй ажил болсон.
- Хүнсний ногооны тариалалт жилээс жилд нэмэгдэж байна.
- Тариаланчдын мэдлэг сайжирсан.
- Мал аж ахуйн бодлогын бичиг баримт боловруулсаны үр дүнд малчин өрхийн орлого нэмэгдэж малын үүлдэр угсаа сайжирч нэг малаас авах ашиг шим нэмэгдсэн.

Дутагдалтай тал:

- Сумдад ажиллах боловсон хүчин дутагдалтай. 16 сум 1 тосгонд 2 агрономч, 1 инженер ажиллаж байна.
- ААН-үүд агрономч, механикч, инженер дутагдалтай.
- Ойн зурвас байгуулах ажлыг аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгасан боловч хангалтгүй хэрэгжиж байна
- Мод үржүүлгийн газар байгуулахад газрыг дуудлага худалдаагаар авдаг нь мод үржүүлгийн төв байгуулахад хүндрэлтэй байна.
- Хүнсний ногооны үр үржүүлгийн аж ахуй байгуулахад стандартын шаардлага хангасан зоорьгүй учир хийгдэхгүй байна.
- Хамгаалагдсан хөрсөнд жимс, жимсгэнэ тариалалт бага байна.
- Сум дундын техник үйлчилгээний төв байгуулах хөрөнгийн асуудал шийдэгдээгүй

1.3. БУЛГАН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Аймгийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд салбарын 3 зорилтын 9 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилт 94.0 хувьтай үнэллээ. Үүнд: 100 хувь хэрэгжсэн 5 арга хэмжээ, 90 хувь хэрэгжсэн -1 арга хэмжээ, 70 хувь хэрэгжсэн 2 арга хэмжээ байна. Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн хийгдсэн гол үр дүн нь гарсан гэж үзсэн.

II. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ

ХХААХҮ-ийн сайд, Аймгийн Засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд нийт 7 зорилтын 44 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг 95.4 хувь гэж үнэлэв.

ГЭРЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ
Мал аж ахуйн салбарын чиглэлээр	100%
Газар тариалангийн салбарын чиглэлээр	86.6%
Хүнсний салбарын чиглэлээр	93.3%
Хөнгөн үйлдвэр, хоршооны салбарын чиглэлээр	85,0%
Жижиг дунд үйлдвэрийн салбарын чиглэлээр	92,5%
Малын удмын сангийн чиглэлээр	100%
Судалгаа хөгжлийн төвийн чиглэлээр	95%
Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны чиглэлээр	100%
Дундаж үнэлгээ	94.0%

2.2. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

ХХААХҮ-ийн сайдын 2023 оны 18 дугаар тушаалаар ХХААГ-ын бүтэц орон тоо шинэчлэгдэн, 4 алба, 24 орон тоогоор төрийн үйлчилгээг явуулж байна. Шинээр Хяналтын албан байгуулагдаж, салбарын чиглэлийн 5 улсын байцаагч, хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна.

Энэ онд улсын төсвийн хөрөнгөөр болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, технологийн ажлыг удирдан зохион байгуулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг өсгөх, хангамж, аюулгүй байдал, чанарыг сайжруулахад гол анхаарлаа чиглүүлж ажиллаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 125 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, хэрэгжилт 95.2 хувиар үнэлсэн. Төлөвлөгөөн туссан шалгуур үзүүлэлтүүд үр дүнтэй хэрэгжсэн. 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 105 арга хэмжээ, 90 хувь хэрэгжсэн 7 арга хэмжээ, 70 хувь хэрэгжсэн 9 арга хэмжээ, 50 хувь хэрэгжсэн 1 арга хэмжээ, 30 хувь хэрэгжсэн 3 арга хэмжээ байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай”- арга хэмжээ:

1. **Аймгийн төв болон сумдад мал нядалгааны цэг байгуулж, хүнсний эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх**-Аймгийн хэмжээнд нэгдсэн загвараар мал нядалгааны газар байгуулах зорилгоор мал нядалгааны нэг маягийн цехийн барилгын даалгаврыг зураг төслийн "Оргил цамхаг констракшн" ХХК-д хүргүүлсэн. Бүрэгхангай суманд мал мах бэлтгэл, нядалгааны цэг барьж байна.
2. “Булган мах маркет” ХХК 2023 онд Ирэн Улс руу 370 тн мах бэлтгэж гаргасан. БНХАУ руу мах гаргахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Дулааны аргаар мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй. "Махны экспортын шинэ боломж-Булган аймагт хэлэлцүүлэг форум зохион байгуулж мэргэжилтэн, малчид хамрагдсан.
3. **Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх**-Шинээр усалгаатай тариалан эрхлэх боломжтой талбайн судалгааны ажлыг 9-р сард хийсэн. Сэлэнгэ сумын “Өрмөгтэй” ХХК усалгааны систем авахаар “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл”-д хамрагдах хүсэлтээ ХХААХҮЯ-д хүргүүлсэн.
4. **Үр тарианы дундын үтрэм байгуулах**-Хутаг-Өндөр суманд сум дундын үтрэм байгуулах газрыг шийдвэрлэхээр болсон.

2.3. СУМДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГТАЙ 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАСАН ГЭРЭЭГ ҮНЭЛСЭН ДҮН

д/д	Сумдын нэрс	Мал аж ахуй	Газар тариалан	Хүнс/ЖДҮ	ХАА-н тасаг үнэлгээ
1	Баян-Агт	98.5	88.2	82.1	89.6
2	Баяннуур	88	87.9	78	84.6
3	Бугат	90	97	75.6	85.9
4	Булган	95	97.5	82.3	91.6
5	Бүрэгхангай	95.2	98.9	78	90.7
6	Гурванбулаг	88.1	97	85.5	88.5
7	Дашинчилэн	87.5	94.3	79.8	87.2
8	Могод	98.3	88.9	97.5	94.9
9	Орхон	93.5	97.6	95	95.4

10	Сайхан	90.2	98	97.9	95.4
11	Сэлэнгэ	98	98.6	79.6	92.1
12	Тэшиг	93.1	89	83	88.4
13	Хангал	88.5	98.4	83.7	90.2
14	Хишиг-өндөр	97	97.9	87.1	94.0
15	Хутаг-өндөр	96	98	98	97.3
16	Рашаант	93	97.3	86	92.1
Ерөнхий үнэлгээ		93.1	95.3	84.9	94.1

2.4. ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Үзүүлэлт	үнэлгээ
ХХААХҮЯ-ны хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар	97.7
Дундаж үнэлгээ	97.7

III БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2021 оны 217 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг тооцон Гүйцэтгэлийн мэдээллийн системд тайлагнасан. 4 зорилтын хамааралтай 33 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж, **99 хувьтай** үнэлсэн. /Хэрэгжилтийг хавсаргав./

3.2. Хэрэглэгчийн үнэлгээ

Аймгийн Засаг даргын тамгын газраас нэгдсэн үнэлгээ хийхээр аймгийн ХШҮ-ний журамд тусгасан. Тус газар төсөв байхгүй тул хийгдээгүй.

IV . ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

2023 онд хөнгөн үйлдвэр, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл нэмэгдэж 6 салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргасан. Хүнсний салбарын 33 шалгуур үзүүлэлтийг 92.6 хувь, Мал аж ахуйн 28 шалгуур үзүүлэлтийг 99.7 хувь, газар тариалангийн 53 шалгуур үзүүлэлтийг 95,7 хувь, Хөнгөн үйлдвэр 25 шалгуур үзүүлэлтийг 97,8 хувь, жижиг дунд үйлдвэр 16 шалгуур үзүүлэлтийг 100 хувь, хоршооны салбарын 16 шалгуур үзүүлэлтийг 99,3 хувиар нийт дундаж үнэлгээ 97,6 хувиар дүгнэгдсэн.

САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлтүүд		Үнэлгээ	Дундаж хувь
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Хүнс	92.6	97.6
	Мал аж ахуй	99.7	
	Газар тариалан	95.7	
	Хөнгөн үйлдвэр	97,8	
	Жижиг дунд үйлдвэр	100	
	Хоршооны салбар	99,3	

1. Үйлдвэрлэлт, борлуулалтын мөнгөн дүн мэдээлэл Статистикийн хэлтсийн 2023 оны 11 сарын байдлаар /СХ гэдэг нь/

2. Аймгийн хэмжээнд 3 удаа, Улаанбаатар хотод 1 үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 800,0 орчим сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.

3. Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд арилжааны банкаар олгогдож байгаа зээлэнд 62 аж ахуй нэгж хамрагдаж 5,3 тэрбум, ЖДҮДС-ийн зээлэнд 8 аж ахуйн нэгж хамрагдаж 900,0 сая төгрөг, ХХС-аас хүнсний чиглэлээр 3 аж ахуйн нэгж 84,0 сая төгрөгийн зээл авсан байна. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн буцалтгүй тусламаар 4 хоршоо, 4 аж ахуй нэгжид 60,0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн.

4. 2023 онд үйлдвэрийн аргаар “Хатан мээж хайрхан” ХХК, “Эко хүнс “ХХК-ууд үйлдвэрийн аргаар сүүн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 1383,67 тн үйлдвэрлэсэн байна.

5. Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оноос нэмэгдэж, экспортод гаргасан махны хэмжээ өссөн. Үйлдвэрийн мэдээг сумын ХААТ-ийн судалгаа, малын махны үйлдвэрлэлтийг МҮА-ны зах зээлд нийлүүлсэн болон нөөцөлсөн махны хэмжээгээр гаргасан.

Ү. САЛБАРЫН 2023 ОНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

- Малчдыг мэдлэгжүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор цаг үеийн болон мал аж ахуйн салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийж , нийт 2160 хүн хамруулсан.
- "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийн хүрээнд 140 зөгийн бүл, 608 толгой шилмэл сүрэг, цэвэр үүлдрийн 64 бух, хадлангийн иж бүрэн техник тоног төхөөрөмж тракторын хамт, хүлэмж 22, нийт 1,927.0 сая төгрөгийн санхүүжилтийг сумдад олгосон байна.
- “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг дүгнэж үзэхэд аймгийн дүнгээр 90.3 хувиар хангалаа.
- Нийт сүрэгт эзлэх өндөр ашиг шимтэй малын тоо 24.4 хувьд хүрсэн байна

- Эрчимжсэн аж ахуйн мал, амьтны тоо толгойг 8 хувиар нэмэгдүүллээ. /Улсын төсвийн хөрөнгөөр Сэлэнгэ суманд 5-н өрхөд 60 бүл зөгий, Хутаг-Өндөр суманд 4- өрхөд 80 бүл зөгий, нийт 140 бүл зөгийг гэрээ байгуулан олгосон. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас махны үхэр үржүүлэхээр “Цогтан тал” ХХК, Тэшиг сумын “Залман Хангай” ХХК тус бүр 100.0 сая төгрөг, Хутаг-Өндөр сумын “Гурт Беред” ХХК 60.0 сая, махны хонь үржүүлэхээр Сэлэнгэ сумын “Эко Оргоник” ХХК 100.0 сая, сүүний үхэр үржүүлэхээр Бугат сумын “Бугат Агро” ХХК 100.0 сая, нийт 558.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд хамрагдсан/
- Аймгийн хэмжээнд хүнсэнд 464,3 мянган толгой, зах зээлд 714.9 мянган толгой, нийт 1189.5 мянган толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулсан.
- Хөдөөгийн хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 худаг, малчдын санаачилгаар 2 худаг нийт 18 инженерийн хийцтэй худаг гаргасан. Мөн Байгаль хамгаалах сангийн 65.0 сая төрөгийг 10 сумдад булаг шандын эхийг хамгаалсан.
- 2023 оны ургац хураалтаар нэгжийн ургац 14.9 буюу улсын дундажаас дээгүүр Улсад 1-рт, нийт хураан авсан ургацаар Улсад 3-рт орсон байна. /Улаанбуудай 37087 га талбайд тариалж, /нэгжийн ургац 14.9 цн/, бусад үр тариа 2150,5 га талбайд тариалж, 1746,2 тн, малын тэжээл 6682 га талбайд тариалж, 17381 тн, тосны ургамал 9771 га талбайд тариалж, 4423 тн хураан авсан. Энэ онд 37460 га талбайд уринш бэлтгэсэн. /
- Төмс 433,3 га талбайгаас 3357,3 тн хураан авч хангамж 100 хувь, хүнсний ногоо 300 га талбайгаас 2476 тн хураан авч хангамж 49.6 хувь болж нэмэгдсэн.
- Булган сумын үйлдвэржилтийн бүсэд барихаар төлөвлөж 1000 м.кв бүхий өвлийн хүлэмж байгуулах зураг төсвийг боловсруулсан.
- Хутаг-Өндөр суманд сум дундын үтрэм байгуулах газрыг шийдвэрлэсэн.
- Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээлэнд тус аймгаас нийт 62 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, 5.381.4 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- Гурванборхууд” ХХК-ийн "Арвайн гурил", "Сүргийн нуга" ХХК-ийн "Зөгийн бал" орон нутгийн органик бренд бүтээгдэхүүнээр баталгаажсан.
- “Гурванборхууд” ХХК нь Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд 2023 оны Шилдэг 35 хүнсний үйлдвэрийн нэгээр шалгарлаа.
- Булган аймгийн Засаг даргын нэрэмжит "Улсын залуу аварга тогооч нарын уралдаан-2023" уралдаанд 18 аймаг 9 дүүргийн нийт 200 гаруй тогооч хамрагдаж, Булган аймгийн БРЭНД ХООЛ БОЛОХ "ТЭРГҮҮН ШИМТ ШӨЛ"-ийг бий болсон.

- Аймгийн хэмжээнд хоршоо хөгжүүлэх сан нь 3.9 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 28 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр энэ онд аймагт 1.1 тэрбум төгрөгийн эх үүсвэр хуваарилагдаж, 11 төсөлд 1.105.331.412 төгрөгийн зээл олгож 39 ажлын байр шинээр бий болгож 31 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.
- Аймгийн хоршоодыг чадавхжуулах "Хоршооны сайн засаглал" 2 үе шаттай сургалтанд 26 хоршооны 80 гаруй удирдлага, гишүүдийг чадавхжуулж, 60.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн дэмжлэгийг 8 аж ахуйн нэгжид олгосон.
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоол, Салбарын хяналтын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-05/04, 08-00-02/05, 08-00-02/06 08-00-02/13, 08-00-02/15 дугаартай удирдамжуудийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар 14 хоол үйлдвэрлэлийн газар, 6 гурилан бүтээгдэхүүний цех, 1 сүү, сүүн бүтээгдэхүүний цех, 2 ус савлах цех, хүнсний худалдааны 30, газар тариалангийн 15 буюу нийт 68 объектыг 8.10.1, 8.7.1, 8.11.1, 8.20.1 кодтой хяналтын хуудсуудаар үнэлэхэд 11 бага, 42 дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлтийн түвшин дунджаар 66.4%, эрсдэл үүсэх магадлал дунджаар 33.5 хувьтай үнэлэгдлээ. Үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 357 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, шалгалтын явцад 508 зөрчил илрүүлж, шалгалтын явцад 157 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 351 заалттай 50 албан шаардлага хүргүүлж ажилласан. Албан шаардлагын биелэлт 93.6 хувьтай байна.

Ү. ДҮГНЭЛТ

1.2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ерөнхий дундаж дүн 95.0 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5 хувиар өссөн байна. Үнэлгээний дүнгээс харахад төлөвлөсөн ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна.

2. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, ажлуудыг зохион байгуулж ажилласан, газар тариалан, мал аж ахуйн салбарт өсөлт гарсан, орон нутагт хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны салбарыг хөгжүүлэх чиглэлд үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан байна.

3. Удааширалтай буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ нь төсөв санхүүжилт шийдэгдээгүй жил бүр төлөвлөгөөнд орж ирдэг.

4. Салбарын зарим шалгуур үзүүлэлтийг тооцоход статистик мэдээлэл гараагүй байгаагаас тооцох боломжгүй байна.

- 2024 төлөвлөлтөнд анхаарч, ажлын гүйцэтгэл, үр дүнг зөв тайлагнаж, тоонд биш чанарт анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь ХШҮ-ний дүнгээс харагдаж байна.
5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ижил төстэй олон арга хэмжээ төлөвлөсөн, шалгуур оновчтой бус тавиагүй зэрэг нь хэрэгжилт тооцоход хүндрэлтэй байна.
 6. Аймгийн тайлан 11-12 сарын -5ны дотор гаргадаг, үүнтэй холбоотой тоон мэдээлэл эцэслээгүй өссөн дүнгээр тавих, зөрсөн тоон мэдээлэл өгөх зэрэг ХШҮ-ээр хэрэгжилтийн хувь бүрэн тавигдахгүй байх асуудлууд гарч байна.

1.ХХААГ-ын үйл ажиллагааны хяналт шинжилгээ үнэлгээний дүнг нэгтгэн авч үзвэл:

Үнэлгээний үзүүлэлтүүд		Хяналт шинжилгээ үнэлгээ хувь
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	91.6
	Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	90,3
	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт	94
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	96,4
	Сайд, ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээний биелэлт	94
	ХХААГ, сумдын Хөдөө аж ахуйн тасагтай байгуулсан гэрээний биелэлт	94,1
	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	97,7
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	99,3
	Хэрэглэгчийн үнэлгээ	-
Үйл ажиллагааны үр дагварын үнэлгээ	Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт	97,6
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		95.0

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 95.0 хувь 4.7 оноогоор үнэлэгдэж байна.

ҮІ. ЗӨВЛӨМЖ

- Сумын ХАА-н тасгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, тайлан мэдээг хугацаанд ирүүлэх
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтөнд анхаарах, шалгуур үзүүлэлт тодорхой байх
- Удааширалтай болон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг анхаарч, хэрэгжүүлэх боломжийг судалж, төлөвлөх
- Байгууллагын вэб сайтыг өргөтгөх, сайжруулах, төсвийг шийдүүлэх
- Дэд хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх

- Хүнсний хангамж- аюулгүй байдал”-ыг хангах төлөвлөгөө боловсруулах
- Ойн зурвас байгуулах ажил эрчимжүүлэх
- Үр тарианы дундын үтрэм байгуулах ажлыг эрчимжүүлэх
- Хутаг-Өндөр суманд тус бүр 500 тонны багтаамжтай механикжсан зоорь барих ажлын эрчимжүүлэх
- Аймгийн төв болон сумдад мал нядалгааны цэг байгуулж, хүнсний эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА АЖ АХУЙН

АЛБАНЫ ДАРГА

Ч.ШҮРЭНЦЭЦЭГ

БАТАЛГААЖУУЛСАН:

ГАЗРЫН ДАРГА

Ч.АМГАЛАН

2023 оны 12-р сарын 20-ны өдөр

